

JENESYS2017

Азийн олон улсын хүүхдийн кино наадам 2017 (урилгын хөтөлбөр) –н тэмдэглэл
(Оролцсон улс: Монгол Улс / Сэдэв: Азийн олон улсын хүүхдийн кино наадам
2017 хөтөлбөрийн тэмдэглэл)

1. Хөтөлбөрийн агуулга

Япон Улсын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх зорилготой 「JENESYS2017」 хөтөлбөрийн дагуу Монгол Улсаас ахлах сургуулийн 10 сурагчийг 2017 оны 11 сарын 21 ний өдрөөс 11 сарын 29 ний өдөр хүртэлх хугацаанд урьж, Японы сургуулиар айлчлах зэрэг харилцааны хөтөлбөрөөр дамжуулан Японы ахлах сургуулийн сурагчид болон иргэдтэй дотно нөхөрлөлийн харилцаа бий болгосон төдийгүй Японы улс төр,эдийн засаг, түүх, дэвшилтэт аж үйлдвэр уламжлалт аж үйлдвэр , соёлтой танилцах байгууламж ба хөдөө орон нутгийн хоттой танилцан, Япон улсын талаарх олон талт ойлголтийг авсаны зэрэгцээ Япон Монгол хоёр улсын хүүхэд залуучуудын найрамдалт харилцааг гүнзгийрүүлж чадсан.

Гол үйл ажиллагаа болох Хоккайдо мужийн Китами хотод явагдсан 『11 дэх удаагийн Азийн олон улсын хүүхдийн кино наадам 』 -д оролцон, Японы ахлах сургуулийн сурагчид болон нутгийн иргэдтэй харилцаагаа гүнзгийрүүлэн, Япон улс болон Японы соёлын талаарх ойлголтыг өгөхийг зорисон болно. Соёлын тал дээр зөвхөн кино наадамд оролцоод зогсохгүй дэлхийд алдартай Японы хүүхэлдэйн кинотой холбоотой хэд хэдэн музей үзэж сонирхсон. Орчныг хамгаалахтай холбоотойгоор хог хаягдал цэвэрлэх байгууламжтай танилцан орчныг хамгаалах арга мэдлэгийг олж авсан.Мөн далайн амьтны үзэсгэлэнгээр айлчлан, Хоккайдо мужийн жинхэнэ бодит байгальтай ойрхон үзмэрүүдийг үзэж, тус мужийн нутгийн онцлогтой ойртон танилцах боломжийг бий болгосноор байгаль орчны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд тус дөхөм болж чадсан.

【Оролцсон улс ・ Хүний тоо 】

Монгол Улс 10 хүн (Ахлах сургуулийн сурагч 9 хүн + Удирдагч багш 1 хүн)

【Айлчилсан газар】

Токио хот, Хоккайдо муж

2. Өдрийн хөтөлбөр

- 11 сарын 21 (Мя) Нарита олон улсын онгоцны буудалд буух
Хөтөлбөрийн танилцуулга
- 11 сарын 22 (Лх) Сүгинами дүүргийн хүүхэлдэйн киноны музей үзэх
Хоккайдо муж руу явах
- 11 сарын 23 (Пү) Китами хотын захиргаа
Хүлээн авах хүндэтгэлийн ёслол (Байр: Китами хотын иргэдийн ордны бага танхим)
Кино наадмын шалгарсан бүтээлүүдийг үзэх 【 кино наадамтай холбоотой 】 (Байр: Китами хотын иргэдийн ордны бага танхим)
Карлинг спорттой танилцах
- 11 сарын 24 (Ба) Хойд нутгийн далайн амьтны үзэсгэлэн (Уулын усны амьтдын үзэсгэлэн) үзэх
Сургуулийн харилцааны хөтөлбөр (※Хэд хэдэн группд хуваагдан 2 мэргэжлийн колледжийн оюутнуудтай харилцах)
- 11 сарын 25 (Бя) Охотцийн олон улсын харилцааны хөтөлбөрт оролцох (Китами хотын залуучууд хөдөлмөрийн зал)
Кино наадам • Шагнал гардуулах ёслолд оролцох (Байр: Китами хотын иргэдийн ордны их танхим)
Харилцааны хөтөлбөр: Үдэлтийн үдэшлэг (Байр: Китами хотын залуучууд хөдөлмөрийн зал)
- 11 сарын 26 (Ня) Абашири гяндан музей үзэх
Токио руу буцах
- 11 сарын 27 (Да) Японы шинжлэх ухаан ирээдүйн музей үзэх
Фүжико • Ф • Фүжио музей үзэх
- 11 сарын 28 (Мя) Худалдааны байгууламжтай танилцах
Токио хотын 23 дүүргийн хог цэвэрлэх байгууламжтай (Шибүяа үйлдвэр) танилцах
Тайлан цуглаан
- 11 сарын 29 (Лх) Нарита Шиншёожи хийдийг үзэх
Нутаг буцах

※ Энэ жилийн кино наадмын сэдэв: 「Сургуулийн багш」

3. Хөтөлбөрийн явцын зураг

	
11 月 22 日【視察】 杉並アニメーションミュージアム	11 月 23 日【表敬訪問】 北見市
11сарын22【үзвэр】 Сүгинами дүүргийн хүүхэлдэйн киноны музей	11 сарын 23【Хүндэтгэлийн айлчлал】 Китами хот
	
11 月 23 日【ウェルカムセレモニー】 北見市民会館 小ホール	11 月 23 日【体験】 カーリング体験
11 сарын 23【Хүндэтгэлийн айлчлалын ёслол】 Китами хотын иргэдийн соёлын ордны бага танхим	11 сарын 23【Биетээр хийх】 Карлинг спорт

	
11 月 24 日【学校交流】 学校名①北見情報ビジネス専門学校	11 月 24 日【学校交流】 学校名②オホーツク福祉専門学校
11 сарын 24 【 Сургуулийн харилцаа 】 Сургуулийн нэр①Китами хотын мэдээлэл бизнесийн коллеж	11 сарын 24 【 Сургуулийн харилцаа 】 Сургуулийн нэр②Охотцкийн нийгмийн халамжийн коллеж
	
11 月 24 日【交流会】 瑞野町農業者トレーニングセンター	11 月 25 日【参観】 オホーツク国際ふれあい広場
11 сарын 24 【 Харилцааны хөтөлбөр 】 Танночёо тариаланчдын сургалтын төв	11 сарын 25 【 Оролцох 】 Охотцкийн олон улсын харилцааны танхим



11 月 25 日【映画祭】
映画祭本選大会・授賞式

11 сарын 25 【 Кино наадам 】
Кино наадмын ажиллагаа • шагнал гардуулах
ёслол



11 月 25 日【交流会】
アフターパーティー

11 сарын 25 【 Харилцааны хөтөлбөр 】
Үдэлтийн үдэшлэг



11 月 26 日【参観】
博物館 網走監獄

11 сарын 26 【 Үзвэр 】
Абашири гяндан музей



11 月 27 日【参観】
日本科学未来館

11 сарын 27 【 Үзвэр 】
Японы шинжлэх ухаан ирээдүйн музей

	
11 月 28 日【視察】 東京 23 区ごみ処理場（渋谷工場）	11 月 28 日【報告会】
11 сарын 28 日【 Үзэж танилцах 】 Токёо хотын 23 дүүргийн хог цэвэрлэх байгууламж （Шибуяа үйлдвэр）	11 сарын 28 【 Тайлан цуглаан 】

4. Оролцогчдын сэтгэгдэл

- ◆ Сургуулийн харилцааны хөтөлбөр болон сургуулийн дотоод орчинтой танилцаж, Японы уламжлал, технологийн чадвар зэрэг олон зүйлийг сурч мэдэж авлаа.
- ◆ Хоккайдо мужид өнгөрөөсөн өдрүүд их сайхан хөгжилтэй байсан. Олон найз нөхөдтэй болсон. Ноднингийн хөтөлбөрөөс Токиод дахь хугацаа урт байсан нь сайн байлаа.
- ◆ Нутаг буцсан хойноо Японы соёл, ёс заншлын талаар сургуулийнхаа найзуудад ярьж танилцуулах болно.

5. Хүлээн авсан талын сэтгэгдэл

◆ Сургуулийн харилцааны хөтөлбөрт хамт оролцсон коллежийн оюутнууд

Энэ удаагийн харилцааны хөтөлбөрөөр дамжуулан ойлгож авсан зүйл бол хэдий хэл усаа ойлголцохгүй боловч үйл хөдлөл, дохио зангаагаар болон нүүрний хөдлөл, сэтгэлийн илэрхийлэлээр хоорондоо ойлголцож болдог гэдэг зүйл юм. Хэлээ ойлголцохгүй байх тусам бие биедээ анхаарал тавьж, бие биеэ илүү их сонирхож, хоорондоо харилцсанаар өөр улсын соёлд суралцан, бие биетэйгээ харилцаж чаддаг юм байна гэдгийг ойлгож авсан.

◆ Өөр улсын ахлах сургуулийн сурагчид

Анх удаа өөр улсын хүүхдүүтэй танилцан, маш хөгжилтэй байсан. Хоорондоо хэлээ ойлголцохгүй хүндрэлтэй байсан хэдий ч үнэхээрийн үнэтэй туршлага болсон.

◆ Айлчилсан газрын хүмүүсийн сэтгэгдэл

Оролцогч хүүхдүүд бүгдээрээ идэвхтэй байсан ба өөрийн улстай ялгаатай байдал зэрэг олон зүйлд сонирхолтой хандаж, Японд олж авсан мэдлэг туршлагаа өөрийн улсдаа харьсан хойноо дамжуулж танилцуулах сэтгэл дүүрэн байгаа нь мэдрэгдсэн.

6. Оролцогчдын дамжуулсан мэдээлэл

Facebook post by Sukhbat Delger (Mongol Aicff Jenesys) dated 11月30日 10:23. The post mentions a film festival and a group photo. The post text is: "Азийн хүүхдийн кино фестиваль амжилттай боллоо. Биднийг найрсгаар угтан авсан Япон орон, хүмүүст монголын баг баярлалаа. — Munkh Blyさんと一緒にです。"

JENESYS 2017 group photo on stage.

Two photos of participants in traditional Mongolian attire.

Three photos of participants in various settings, including a group photo with a '+5' overlay.

Photo of participants with a '+10' overlay.


Photo of participants with a '+5' overlay.

Photo of participants with a '+10' overlay.

Photo of participants with a '+5' overlay.

	
概要) 有意義な訪日プログラムをサポートする 同行通訳者への感謝	概要) 訪日の様子
モンゴル語) Үр өгөөжтэй Япон дахь айлчлалын явцад дэмжиж тусалсан орчуулагч нартаа баярлалаа,	モンゴル語) Японд байхдаа

7. Тайлангийн цуглаан дээр нутагтаа харьсан хойноо хийх ажлаа төлөвлөв

	概要) 1) 学校で1日、感謝デーを実施します。 (一か月以内に) 2) 個人FBを通して一人一人に配信します。
---	---

3) 「文化祭」を実施します。
モンゴル語) 1.Нэг өдөр сургууль дээрээ “ Талархлын өдөр” – г зохион байгуулна. (нэг сарын дотор) 2. Хүүхэд тус бүр өөрсдийн FB нүүр хуудсаар Японы тухай танилцуулна. 3. “ Соёлын өдөрлөг” зохион байгуулна.